# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
## НЭГ. ТӨЛБӨРИЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Байгууллагын нэр | Төлбөрийн актын товч утга | Мөнгөн дүн (сая төгрөгөөр) | Төлбөрийн актын биелэлт | | | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хэрэгжүүлсэн байдал | Биелэлт ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар | Хэрэгж-сэн | Хэрэгжих шатандаа | Хэрэгжүүл-ээгүй | Хувь | |
| I. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ | | | | | | | | | | |
| Байгууллагын дүн (дундаж хувь) | | | | | | | | | | |
| Нийт дүн (дундаж хувь) | | | | | | | | | | |
| II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ | | | | | | | | | | |
| 1 | ГИХГ | Тайлант онд нэр бүхий 2 ажилтанд нийт 324.8 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон. | 0.3 | 2023 онд 2 ажилтанд илүү олгосон 324.8 мянган төгрөгийг Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр төвлөрүүлсэн. | Дотоод албан бичиг №06/08 | + | | | 100% | |
| 2 | | Барьцаа хөрөнгийн дансанд 2015 онд байршуулсан эзэн холбогдогч нь тодорхойгүй 2,000.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө байна. | 2.0 | Барьцаа хөрөнгийн дансанд 2015 онд байршуулсан эзэн холбогдогч нь тодорхойгүй 2,000.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлсэн байна. | | + | | | 100% | |
| Байгууллагын дүн (дундаж хувь) | | | 2.3 | | | | | | 100% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | АЗБХГ | Тайлант онд нэр бүхий 4 ажилтанд нийт 737.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон. | 0.7 | 2024 оны 07-08 дугаар сард төлбөрийн актыг барагдуулна. | Дотоод албан бичиг №11/42 | | | + | 0% | |
| Байгууллагын дүн (дундаж хувь) | | | 2.3 | | | | | | 0% | |
| Нийт дүн (дундаж хувь) | | | 2.3 | | | | | | 67% | |
| Нийт дүн /I+ II+ III/ | | | 2.3 | | | | | | | |

------oOo------

# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
## ХОЁР. АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Байгууллаг-ын нэр | Албан шаардлагын товч утга | Мөнгөн дүн (сая төгрөгөөр) | Албан шаардлагын биелэлт | | | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хэрэгжүүлсэн байдал | Биелэлт ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар | Хэрэгж-сэн | Хэрэгжих шатандаа | Хэрэгжүү-лээгүй | Хувь | |
| I. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ | | | | | | | | | | |
| Байгууллагын дүн (дундаж хувь) | | | | | | | | | | |
| II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ | | | | | | | | | | |
| 1 | Хойд бүс дэх газар | Жилийн эцэст урсгал засварын хэмнэлт 4839.5 мянган төгрөгөөр чухал шаардлагагүй барилгын материал бэлтгэж, нөөцлөн, үлдэгдлээр тайлагнасан. | 4.8 | Жилийн эцэст урсгал засварын зардлаас барилгын материал бэлтгэсэн нь албаны өрөөний засвар хийх гэж төлөвлөсөн байсан. Энэ онд албаны өрөөний засварын ханын ажил хийгдэж байгаа учир материалыг шаардлагатай үед тухай бүр зарлагадан ажиллаж байна. | Дотоод албан бичиг №06-15/26 | | + | | 70% | |
| 2 | | Бараа үйлчилгээний бусад зардлаас хууль тогтоомж сурталчлах сурталчилгааны материал хийлгэхээр 1850.0 мянган төгрөгийг шилжүүлж, материалыг хүлээн аваагүй атал урьдчилж | 1.8 | Хууль сурталчлах сурталчилгааны материал хийгдэж дүрс бичлэг гүйцэт хийгдсэн дуу оруулалт дутуу тул хүлээн аваагүй байна. | | | + | | 50% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гарсан зардлаар тайлагнаагүй. | | | | | | | | |
| Байгууллагын дүн (дундаж хувь) | | | 6.6 | | | | | | 60% | |
| 3 | Зүүн бүс дэх газар | Худалдан авалтыг харьцуулалтын аргаар хийгээгүй | 25.9 | Төсвийн шууд захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хүрээнд 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний худалдан авалт хийгдээгүй байна. Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллана. | Дотоод албан бичиг №16/20 | + | | | 100% | |
| Байгууллагын дүн (дундаж хувь) | | | 25.9 | | | | | | 100% | |
| Нийт дүн /I+ II+ III/ | | | 32.5 | | | | | | 80% | |

------oOo------

# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
## ГУРАВ. ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Байгууллагын нэр | Зөвлөмжийн товч утга | Мөнгөн дүн (сая төгрөгөөр) | Зөвлөмжийн биелэлт | | | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хэрэгжүүлсэн байдал | Биелэлт ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар | Хэрэгжсэн | Хэрэгжих шатандаа | Хэрэгж-үүлээгүй | Хувь | |
| I. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ | | | | | | | | | | |
| 1 | Төвлөрүүлэн | Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 77,380.6 мянган төгрөгийн 39 нэр төрлийн 76 ширхэг үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүй харъяа байгууллагуудад шилжүүлсэн. | 77.4 | Боомт орон нутаг дахь нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас 76 ширхэг хөрөнгийг орон нутаг дахь нэгжүүдэд акт үйлдэн хүлээлгэн өгсөн бөгөөд өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2023 оны 01/2160 дугаар албан бичгээр балансаас балансад шилжүүлэх хүсэлтийг ХЗДХЯ-аар дамжуулан ТӨБЗГ-т хүргүүлсэн боловч тухайн ондоо багтаан шийдвэр гаргаагүй тул 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/859 дугаар тоот албан бичгээр дахин хүсэлт хүргүүлж, хүсэлтийг шийдвэрлүүлэхээр ТӨБЗГ-ын хариуцсан албан хаагчтай 2 удаа очиж уулзсан. ТӨБЗГ-аас | Дотоод албан бичиг №06/08 | | + | | 50% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 07 дугаар сард багтаан шийдвэр гаргаж хүргүүлнэ гэсэн хариу өгсөн. | | | | | | |
| 2 | | Гадаадын иргэн, харьяатын газрын харьяа нэгж газруудын санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн авто тээврийн хэрэгсэл 125,600.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 869,566.5 мянган төгрөг, тавилга эд хогшил 40,085.8 мянган төгрөг, программ хангамж 183,365.6 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 190.0 мянган төгрөгийн нийт 1,218,807.9 мянган төгрөгийн үнэ бүхий 366 нэр төрлийн 1032 ширхэг хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах, дахин үнэлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна. | 0 | 2023 онд байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийн дагуу хөрөнгө актлах, үнэ шинэчлэн тогтоох тухай 01/2169, 01/2170 дугаар тоот албан бичгийг ХЗДХЯ-аар дамжуулан ТӨБЗГ-т хүргүүлсэн бөгөөд ТӨБЗГ-ын 2024 оны 232 дугаар тогтоол, байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/213 дугаар тоот тушаалын дагуу ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг актлах болон үнэ шинэчлэн тогтоож, бүртгэл тайланд тусгасан болно. | | + | | | 100% | |
| | | | 77.4 | | | | | | 75% | |
| II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | Жолоочийн шатахууны тооцоогоор үлдэгдэлтэй байгаа 89.4 мянган төгрөгийн шатахууныг зардлаар тайлагнасан. | 0.1 | Жолооч нарт олгосон шатахууны үлдэгдэл буюу авто машины банканд байгаа үлдэгдлийг тайлант хугацаа тус бүрээр орлогод авах боломжгүй бөгөөд энэ оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бараа материалын тайланд жолооч нарт олгосон шатахууныг агуулах үүсгэн шилжүүлж, үлдэгдлийг бүртгэлээр харуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | | + | | 30% | |
| 4 | ГИХГ | Төсвөөс 29,410.8 мянган төгрөгийг визийн мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, зогсоолын төлбөр, хортон шавьж устгалын зардалд урьдчилж шилжүүлсэн. | 29.4 | Визийн мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлтийн зардлыг сар бүр хуваарилж шилжүүлэх боломжгүй бөгөөд гэрээнд тусгагдсаны дагуу төлбөрийг шилжүүлсэн болно. Цаашид зогсоол, хортон шавьж устгалын төлбөрийг тайлант хугацаанд нь тухай бүр санхүүжилтийг олгож, зөрчлийг давтан гаргахгүй ажиллана. | Дотоод албан бичиг №06/08 | + | | | 100% | |
| 5 | | Монгол Улсаас БНХАУ-ын Хөх хотод суугаа Дипломат төлөөлөгчид олгосон санхүүжилтийн зарцуулаагүй 356.2 юан буюу 170.9 мянган төгрөгийн | 0.2 | БНХАУ-ын Хөх хот дахь ерөнхий консулын газрын нягтлан бодогчийн хариуцлагагүй байдлаас болж төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон холбогдох бичиг баримтыг өгдөггүй байсан. 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан гарсны дараа 2024 | | | | + | 0% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэлэн мөнгөний үлдэгдлийг Гадаадын иргэн, харьяатын газрын санхүүгийн тайланд тусгаагүй байна. | | оны 03 дугаар сард 2023 оны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж өгсөн. Энэ нь манай санхүүжилтийн үлдэгдэл мөн эсэх нь тодорхойгүй байна. Одоог хүртэл манай санхүүжилтийн үлдэгдэл мөн эсэхийг нотлох санхүүгийн баримтаа ирүүлээгүй байна. | | | | | | |
| 6 | | Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ-аас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр 2023 онд 416,796.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй өгснийг бараа материалын дансанд бүртгэсэн. | 416.8 | Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлсэн 416.7 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагад бодитоор хүлээн авч, 3 талаас акт үйлдэн баталгаажуулан хүлээлцсэн. Дорноговь аймгийн ИТХ-ын шийдвэрийг яаралтай гаргаж ирүүлэх тухай хүсэлтийг тухайн орон нутгийн удирдлагад удаа дараа гаргасан боловч шийдвэрийг одоог хүртэл гаргаж ирүүлээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д заасны дагуу бодитоор хүлээж авсан бүх төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлогод бүртгэх ёстой бөгөөд дээрх үндсэн хөрөнгийг орлогод авах шийдвэр гарах хүртэлх хугацаанд бараа | | | + | | 30% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | материалын дансанд түр бүртгэсэн болно. Цаашид Дорноговь аймгийн ИТХ болон ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 7 | | Татварын цахим системийн тодорхойлолтоор 3,898,631.3 мянган төгрөгийн өглөг, авлагын үлдэгдэлтэй байна. | 3898.6 | Тухайн өглөг, авлага нь 2014 оноос эхлэн үүссэн нь татварын тодорхойлолтоор нотлогдож байгаа бөгөөд олон жил болсон өглөг авлагыг цэгцлэх тухай Татварын ерөнхий газар болон ХУД-ын татварын хэлтэст албан бичгээр хандсан боловч одоог хүртэл хэрхэн шийдвэрлэх талаар хариу ирүүлээгүй болно. Хөвсгөл, Ховд, Өмнөговь аймагт үүссэн өр авлагыг цэгцлэх чиглэлийг тухайн орон нутаг хариуцсан ахлах нягтлан бодогч нарт хүргүүлээд байна. 2024 оны 03 дугаар улиралд холбогдох байгууллагад дахин хүсэлт илгээж, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | | | + | | 30% | |
| Байгууллагын дүн (дундаж хувь) | | | 4345.1 | | | | | | 38% | |
| 8 | АЗБХГ | Жолоочийн шатахууны тооцоогоор үлдэгдэлтэй байгаа 139.7 мянган төгрөгийн шатахууныг | 0.1 | Жолооч нарт олгосон шатахууны үлдэгдэл буюу автомашины банканд байгаа үлдэгдлийг тайлант хугацаа тус бүрээр орлогод авах боломжгүй бөгөөд энэ оны | Дотоод албан бичиг №11/42 | | | + | 30% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зардлаар тайлагнасан. | | 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бараа материалын тайланд жолооч нарт олгосон шатахууныг агуулах үүсгэн шилжүүлж, үлдэгдлийг бүртгэлээр харуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | | | | | |
| 9 | | Тэмдэгтийн хураамжийн 2023 оны сүүлийн хагас жилийн тайланг илгээгээгүй, татварын цахим системийн тодорхойлолтоор 706,125.6 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна. | 0.7 | Цаашид тайланг хугацаанд нь илгээж, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна. | | | + | | 50% | |
| 10 | | Ажилтанд олгосон 550.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна. | 0.6 | Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байхад анхааран ажиллаж байна. | | | + | | 50% | |
| 11 | | Шилэн дансны цахим системд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 1,424.2 мянган төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй. | 1.4 | Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байхад анхааран ажиллаж байна. | | | + | | 50% | |
| | Байгууллагын дүн (дундаж хувь) | | 2.8 | | | | | | 45% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Хойд бүс дэх газар | Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч албан хаагчдын гар дээр байгаа "Шийтгэлийн хуудас"-ны тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй. | 0.0 | 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр албан хаагчдын гар дээр байгаа шийтгэврийн хуудас, визийн хуудсыг тоолон баталгаажуулж жагсаалт хийсэн, 2024 оны 01 дүгээр улирлаар мөн үлдэгдлийг тоолж тулгалт хийж, жагсаалт гарган гарын үсэг зуруулан батаалгаажуулсан. | Дотоод албан бичиг №06-15/26 | + | | | 100% | |
| 13 | | Агуулахаас тавьж олгож, автомашинд суурилуулсан мотор, дугуй зэрэг бараа материалыг зардлаас бус үлдэгдлээр бүртгэж, тайлагнасан. | 0.0 | Агуулахад байгаа бараа материалыг холбогдох журмын дагуу баримтыг үндэслэн тухай бүр зарлагадан ажиллаж байна. | | + | | | 100% | |
| 14 | | Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй элэгдлээрээ зардлаа нөхсөн, үлдэх өртөггүй боловч эд ангиудыг засварлаж, зардал гаргаж буй Nissan Patrol маркын авто машиныг бодит үнэ цэнээр үнэлүүлэх саналыг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлээгүй. | 0.0 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 232 дугаар тогтоол, байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/213 дугаар тоот тушаалаар үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон. | | + | | | 100% | |
| | Байгууллагын дүн (дундаж хувь) | | 0.0 | | | | | | 100% | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Баруун бүс дэх газар | Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/25 дугаартай захирамжаар тус байгууллагад Жаргалант сумын тахилт багийн Шинэ суурьшлын бүсэд 1,500 метр квадрат газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн боловч данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” заалттай нийцэхгүй байна. | 0.0 | Тус газрыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А-1/967 дугаар тогтоол, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/214 дугаар тушаалыг үндэслэн 22.5 сая төгрөгийн анхны өртөгөөр данс бүртгэлд бүртгэсэн байна. | Дотоод албан бичиг №14/33 | + | | | 100% | |
| | Байгууллагын дүн (дундаж хувь) | | 0.0 | | | | | | 100% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | Өмнөд бүс дэх газар | Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 47,096,809.00 төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 47.1 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр гүйлгээний агуулга хүлээн авагчийн нэрээр мэдээлнэ" гэсэн заалтыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан. | Албан бичиг №13/55 | + | | | 100% | |
| 17 | | Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, | 0.0 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага албан албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4.7-д "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" гэж заасан заалтыг 100 хувь биелүүлж орон тоонд өөрчлөлт ороогүй ч тоон | | + | | | 100% | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4.7-д “байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт” гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | | мэдээлэл тус бүрээр оруулан ажилласан. | | | | | | |
| 18 | | Шилэн дансны нэгдсэн системд 159 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 0.0 | 2023 оны 08 дугаар сард сар бүр байршуулах мэдээллийг мэдээлэлгүй хоцроож 08 дугаар сарын 18-ны өдөр мэдээллээ оруулж илгээсэн нь хоцорсон төлөвтэй болсон. Энэ онд шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээллэдэг байх" гэж заасны дагуу тайлант онд мэдээллэх хугацаа болсон 88 мэдээллээс 88 мэдээллийг мэдээлж хугацаа хоцроосон мэдээлэлгүй зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | | + | | | 100% | |
| | Байгууллагын дүн (дундаж хувь) | | 47.1 | | | | | | 100% | |
| Нийт дүн (дундаж хувь) | | | | | | | | | 76% | |

------oOo-----